



ЕСҮС ХРИСТИЙН ГАЙХАМШИТТ АМБДРАЛ

ЕСҮС ХРИСТИЙН ГАЙХАМШИГТ АМЬДРАЛ

Есүс Христ бол зөвхөн олон жилийн өмнө амьдарч байгаад нас барсан алдартай хүн байсангүй. Тэр гэмт хүн төрөлхтнийг гэм, сатан ба үхлээс аврахын тулд өөрийн амийн цусыг өгөхөөр дэлхийд хүн болж амьдарсан Бүтээгч Бурхан юм. Тэр өнөөдөр ч амьд бөгөөд Түүн рүү ирэгч бүгдэд мөнх амийг өгдөг билээ.

Есүс Христийг хүлээж авах ба Түүнээс татгалзах нь амь ба үхлийн асуудал **“Хүүтэй хүнд амь бий. Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй”** (1 Иохан 5:12), **“Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв.”** (Үйлс 4:12).

Та Есүс Христийн гайхамшигтай амьдралыг судлаж байхад чинь Бурхан танд илүү бодитой болох болтугай ! **“Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.”** (Иохан 17:3) Та Есүсийг зүрх сэтгэлдээ өөрийн Аврагч Эзэнээр хүлээн авсан уу? Хэрэв үгүй бол өнөөдөр үүнийг хийгээрэй.

Эхэнд үг байсан, Үг нь Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Энэ нэгэн эхэнд Бурхантай хамт байсан. Бүх юмс Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан.
-Иохан 1:1-3, 14а

Учир нь Түүн дотор тэнгэр ба газар дахь бүх юмс бүтээгдсэн.Бүх юмс Түүгээр болон Түүний төлөө бүтээгдсэн байна. Тэр бүх юмсын урьд байна....
-Колоссай 1:16-17

Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олон хэсгээр болон янз

бүрийн арга замаар айлдеан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд Өөрийн Хүүгийн дотор бидэнд хандаж айлдав. Тэр Хүүгээ бидний өвлөгчөөр томилсон бөгөөд Хүүгээрээ ертөнцийг бүтээсэн билээ.

-Еврей 1:1-2

Есүс тэдэнд, “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Аврахамыг бий болохоос өмнө Би байдаг.” гэж айлдав.

-Иохан 8:58

Харин Хүүгийн тухай Бурхан минь, Таны хаан ширээ үеийн үед. Эзэн, та эхэнд дэлхийн суурийг тавьсан бөгөөд тэнгэр Таны мутрын бүтээл билээ.

-Еврей 1:8а, 10

2 ЗӨНЧ НАР ЕСҮСИЙН АМЬДРАЛЫГ УРЬДААС ЗӨГНӨН ХЭЛСЭН

Тийм учраас Эзэн Оөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. “Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ Иммануел” гэж нэрлэнэ.

-Исаиа 7:14

Харин чиний хувьд, Бетлехем Ефратаа, хэдийгээр чи Иудаагийн бүлүүдийн дунд өчүүхэн авч, Миний төлөө Израилийг захирах Нэгэн нь чамаас гарах болно. Түүний гарч ирэх нь эртнээс, мөнхийн өдрүүдээс байсан юм.

-Мика 5:2

Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг

гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. Давидын сэнтий, түүний хаанчлалд шударга ёс, үнэн зөвийг үеийн үед тогтооход, Түүний засаглал болон энх амгалан нь одоогоос үүрд мөнхөд байх болно.

-Исаиа 9:6-7а

Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн. Үнэхээр тэр бидний өвчнийг Оөртөө тээж, бидний уй гашууг даав. Харин бид Түүнийг Бурхан яллагдаж, цохигдож зовсон гэж бодов. Гэвч Тэр бидний нүглийн төлөө хатгагдан, бидний гэмийн төлөө бяцарчээ.

-Исаиа 53:3а, 4-5а

Есүс Христ....Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Оөрийгөө хоослож, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ. Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Оөрийгөө даруу болгов.

-Филиппой 2:56-8

Есүс тэдэнд: “....Учир нь Би Бурханаас гарч ирсэн билээ....” -Иохан 8:42

Анхны хүн (Адам нь) газрын хөрснөөс, хоёр дахь хүн (Есүс) нь тэнгэрээс юм.

-1Коринт 15:47

Тиймээс Тэр ертөнцөд ирэхдээ “Та өргөл ба тахилыг хүсээгүй, Харин Та Надад бие бэлдсэн.” -Еврей 10:5

Тийнхүү хүүхдүүд нь цус ба махан биеийн тасархай болов. Түүнчлэн Тэр Оөрөө бас тасархай болсон. Ингэснээр Тэр үхлийн хүч буюу диаволыг үхлээрээ устгаж, бүх насаараа үхлийн айдасаар боолчлогдож байсан тэдгээр хүмүүсийг чөлөөлөх юм.

-Еврей 2:14-15

“Учир нь Хүний Хүү хүртэл үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд, мөн Оөрийн амийг олны төлөө золиос болгон өгөхийн тулд ирсэн юм.” гэж айлдлаа -Марк 10:45

Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ гэв.
-Лук 19:10

Бурхан Оөрийн Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ.
-Иохан 3:17

Есүс хариулсан нь: “....Учир нь Би үнэний тухай гэрчлэхээр төрсөн бөгөөд

үүний тулд л ертөнцөд ирсэн. Үнэний хүн бүр Миний дуу сонсоно.” гэж айлдлаа.
-Иохан 18:37б

Христ Есүс нүгэлтнүүдийг аврахаар ертөнцөд ирсэн.....
-Тимот 1:1 5а

Бурхан Оөрийнхөө цорын ганц Хүүг ертөнцөд илгээсэн нь Түүгээр дамжуулан биднийг амьд байлгахын тулд юм....
-1Иохан 4:9а

Харин цаг нь болоход Бурхан эмэгтэй хүнээс Хуулийн дор төрөх Оөрийн Хүүгээ илгээсэн юм. Энэ нь Хуулийн дор байгсдыг золихын тулд юм. Ингэснээр бид хөвгүүд нь адил үрчлэлийг авах юм.
-Галат 4:4-5

Тэнгэр элч Габриелыг Бурхан Галилын Назар хот уруу илгээсэн ажээ. Габриел Давидын удмын Иосиф гэдэг хүнтэй сүй тавьсан онгон бүсгүйн гэрт хүрч ирлээ. Түүнийг Мариа гэдэг байв.... Тэнгэр элч түүнд: “Мариа, бүү ай. Чи Бурханы ивээлийг олжээ. Үзэгтүн, чи хэвлийдээ үртэй болж хүү төрүүлнэ. Түүнийг чи Есүс гэж нэрлэх болно. Тэр Хүү агуу Нэгэн болох ба Хамгийн Дээдийн Хүү гэж дуудагдана.... Түүний хаанчлалд төгсгөл байхгүй байна.” гэсэнд Мариа тэнгэр элчид: Би онгон атал энэ нь яаж бүтэх билээ? гэхэд тэнгэр элч: “Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх Ариун Нэгэн нь Бурханы Хүү гэж

дуудагдах болно.... Учир нь Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй.” гэж хэлэв.

-Лук 1:266-27, 30-37

“Давидын хүү Иосиф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн. Учир нь түүнд олдоод байгаа нь Ариун Сүнснийх юм. Түүнийг Хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Оөрийн ард түмнийг нүглээс нь аврана” гэж хэлэв.

-Матай 1:206-21

....Цезарь Августын зарлиг гарчээ... тооллогод бүртгүүлэхээр бүгд өөр өөрийн төрөлх хот уруу явцгаав. Иосиф.... Галилын Назар хотоос Иудейг зорин Бетлехем хот уруу хүүхэдтэй болсон сүйт бүсгүй Мариагийнхаа хамт бүртгүүлэхээр явав..... Мариагийн нярайлах өдөр нь болж, тэр ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож тэжээлийн тэвшин дотор тавив. Учир нь дэн буудалд тэднийг хоноглуулах өрөө байсангүй. Тэр газар хэдэн хоньчид сүргээ манаад шөнө хээр хоноглож байжээ. Гэнэт Эзэний тэнгэр элч тэдний өмнө зогсож, Эзэний цог жавхлан тэдний эргэн тойронд гийсэнд хоньчид үлэмжийн

айдаст Херөд автжээ. Тэнгэр элч тэдэнд: Бүү айгтүн, харагтүн, би бүх ард түмнийг үлэмж баярлуулах сайн мэдээг та нарт авчирлаа. Өнөөдөр Давидын хотод Аврагч, Эзэн Христ та нарын төлөө мэндэллээ..... даавуунд өлгийдсөн нялх хүүхдийг та нар олж харна. Энэ нь та нарт тэмдэг болно гэлээ. Гэнэт өнөөх тэнгэр элчийн хамт олон тооны тэнгэрлэг дайчид үзэгдэж, Бурханыг магтан, Дээр өндөрт алдар нь Бурханд байх болтугай, доор газарт амар тайван нь Түүний тааллыг олсон хүмүүст байх болтугай гэцгээв.

-Лук 2:1-14

Найман өдрийн дараа Түүний хөвчийг хөндөн Түүнд Есүс гэдэг нэр хайрлав. Түүнийг хэвлийд бий болохоос өмнө тэнгэр элч энэ нэрийг өгсөн ажээ.

-Лук 2:21

Үзэгтүн, Иерусалимд Симеон гэгч зөвт шударга агаад сүсэгт нэгэн байв. Тэр Израилийн тайтгарлыг хүлээж байсан бөгөөд түүний дээр Ариун Сүнс байлаа. Эзэний Христийг үзэхээс нааш өөрийг нь үхэхгүй хэмээн Ариун Сүнс түүнд илэрхийлсэн байжээ. Тэр хүн Сүнсэнд хөтлөгдсөөр сүмд иржээ. Хүү Есүсийн төлөө Хуулийн ёслолыг үйлдэхийн тулд эцэг эх нь Түүнийг сүмд авчрах үед нь

Симеон Хүүг гар дээрээ авч, Бурханыг магтаад, Эзэн, Та Оөрийн үгийн дагуу боол намайгаа амар тайван явуултугай. Учир нь Миний нүд Таны авралыг харлаа. Та үүнийг бүх ард түмний өмнө бэлдсэн билээ. Энэ нь харь үндэстэнд илчлэлийн гэрэл, Таны ард түмэн болох Израилийн алдар нь болой гэжээ. Хүүгийн эцэг эх Түүний тухай хэлсэн энэ үгэнд ихэд гайхаж байлаа. Симеон тэднийг ерөөв.....

-Лук 2:25-34

Херөд хааны өдрүүдэд Иудейн Бетлехем хотод Есүсийг төрсний дараа дорно зүгээс зурхайчид Иерусалимд хүрч ирээд, -Саяхан мэндэлсэн иудейчүүдийн Хаан хаана байна вэ? Бид зүүнтэйд Түүний одыг хараад Түүнд мөргөхөөр ирлээ гэжээ. Херөд хаан болон бүх иерусалимчууд үүнийг сонсоод бачимдаж гэнэ. Тэгээд бүх ахлах тахилч болон хуулийн багш нарыг цуглуулаад, Христ хаана төрөх ёстойг тэр лавлаж эхлэв. Тэд түүнд, -Иудейн Бетлехемд, учир нь эш үзүүлэгчийн бичсэнээрТэд хааны айлдварыг сонсоод замдаа гарав. Тэгтэл тэдний зүүнтэйд харсан од тэдний өмнө явсаар Хүүхдийн байсан газар хүрээд тогтов. Тэд одыг хараад, үлэмж баяр хөөр

болж ихэд баярлажээ. Тэгээд гэрт орж, эх Мариагийн хамт байгаа Хүүг хараад сөгдөн Түүнд мөргөж, эрдэнэсийн хайрцгаа нээгээд алт, гүгэл, мирийг бэлэг болгон барив.

-Матай 2:1-5, 9-11

САТАН ЕСҮСИЙГ ТӨРӨХӨӨС НЬ ӨМНӨ ҮЗЭН ЯДАЖ БАЙСАН 9

Тэнгэрт өөр тэмдэг үзэгдэв. Харагтун, долоон толгойтой, арван эвэртэй агуу том улаан луу (Сатан) байна. Толгойнууд дээр нь долоон титэм байх аж. Түүний сүүл нь тэнгэрийн оддын гурваны нэгийг шавхуурдаж, дэлхий дээр унагав. Луу эмэгтэйг төрмөгц хүүхдийг нь залгихын тулд төрөх гэж буй эмэгтэйн өмнө зогслоо. Тэр эмэгтэй бүх үндэстнийг төмөр таягаар хариулах эрэгтэй хүүхэд төрүүлэв.

-Илчлэлт 12:3-5a

Эзэний тэнгэр элч Иосефын зүүдэнд үзэгдэж Бос. Хүүхдийг эхтэй нь авч Египет уруу зугт. Намайг чамд хэл дуулгатал тэндээ бай. Учир нь Херод

Хүүхдийг хөнөөхөөр эрж хайх гэж байна гэжээ. Иосеф босоод шоноор Хүүг эхтэй нь авч Египетийг зорин хөдөллөө. Тэгээд Херодыг нас бартал тэндээ байв. Херод зурхайчдад мэхлэгдсэнээ мэдээд ихэд хилэгнэв.

-Матай 2:13б-15a,16a

Хүүхэд өсөж, хүчирхэг болон мэргэн ухаанд боловсорсоор байлаа. Бурханы нигүүлсэл Түүн дээр байсан юм. Түүний эцэг эх жил бүр Дээгүүр Өнгөрөх баяраар Иерусалим уруу явдаг байв. Түүнийг арван хоёр настай байхад нь баярын заншил ёсоор тэд мөн тийш явцгаав. Тогтсон хоногуудын тоог гүйцээсний дараа тэд буцахад Есүс хүү Иерусалимд үлджээ... Харин Түүнийг жингийн цуваан дунд яваа хэмээн бодож, аяныхаа нэг өдрийг ардаа өнгөрөөжээ. Тэд Түүнийг төрөл садан болоод танилуудынхаа дунд хайж эхлэв. Тэд Түүнийг олсонгүй. Тэгээд Есүсийг хайн Иерусалим уруу буцан ирэв. Гурван өдрийн дараа тэд Түүнийг сүмд багш нарын дунд суугаад тэднийг сонсож,

мөн тэднээс асууж байхад нь олжээ. Түүний ухаан болон хариултууд нь Түүнийг сонссон бүхний гайхлыг төрүүлж байв. Тэд Түүнийг хараад гайхаж эх нь Түүнд: Хүү минь, Чи юунд бидэнд ингэж хандав? Эцэг бид хоёр чинь санаа зовон Чамайг эрж хайлаа гэхэд, Тэр: Та нар юунд Намайг хайсан юм вэ? Эцэгийнхээ гэрт байх ёстойг минь та нар мэдэхгүй гэж үү? гэв. Есүсийн бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ.

-Лук 2:40-49,52

Бурханаас илгээгдсэн нэгэн хүн байсан ба нэр нь Иохан юм. Иохан: Эш үзүүлэгч Исаиагийн айлдсан "ЭЗЭНий замыг шулуун болгогтун" гэж цөлд хашгирах нэгний дуу бол би билээ гэж хэлэв. Дараа өдөр нь Иохан өөр уруу нь ирж яваа Есүсийг хараад: "Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун" гэв. Иохан гэрчилж: Сүнс тэнгэрээс тагтаа мэт буун ирж, Түүн дээр тогтохыг би харсан. Би Түүнийг таниагүй. Харин усаар баптисм хүртээлгэ хээр намайг илгээсэн Тэр "Хэний дээр Сүнс тагтаа мэт буун ирж тогтохыг чи харна, Тэр бол Сүнсээр баптисм хүртээгч мөн" гэж надад айлдсан юм. Би харсан. Энэ бол Бурханы Хүү мөн гэдгийг би гэрчилж байна гэж хэлэв.

-Иохан 1:6,23,29,32-34

Есүс баптисм хүртээд, голын уснаас тэр даруй гарах үед тэнгэр заагдаж, Бурханы Сүнс тагтаа лугаа адил бууж, Түүн дээр ирэхийг тэр харав. Тэнгэрээс: Энэ бол Миний хайрт Хүү. Түүнд Миний таалал оршдог гэх дуу гарлаа.

-Матай 3:16-17

Соригч ирээд, Түүнд: Хэрэв Чи Бурханы Хүү мөн бол энэ чулуунуудыг талх бол гэж тушаа гэв. Гэвч Есүс: “Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна” гэж бичигдсэн байдаг гэж хэлэв. Тэгээд диавол Түүнийг ариун хотод аваачиж, сүмийн орой дээр зогсоогоод, Түүнд: Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол доошоо үсэр. Учир нь, “Чамд санаа тавих үүргийг Тэр тэнгэр элч нартаа өгнө. Тэд гар дээрээ Чамайг өргөөд авч явна. Эс тэгвэл Чи хөлөө чулуунд цохьчих вий.” гэж бичигдсэн байдаг шүү дээ гэв. Есүс, “Өөрийн Бурхан Эзэнээ бүү сорь” гэж бас бичигдсэн байдаг гэв. Диавол дахин Түүнийг асар өндөр ууланд аваачаад

дэлхийн бүх хаанчлалуудыг болон сүр хүчийг нь үзүүлээд: Хэрэв Чи сөхрөн, надад мөргөвөл, энэ бүхнийг би Чамд өгье гэж хэлэхэд Есүс: “Зайл, Сатан аа! Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил” гэж бичигдсэн байдаг юм гэж хэллээ.

-Матай 4:3-10

Учир нь Тэр Өөрөө соригдон зовлон эдэлж байсан тул сорилтонд орогсод тусалж чадна.

-Еврей 2:18

Есүс Галил нуурын эргээр явж байхдаа нуурт тор тавьж буй Симон, Симоны дүү Андрей нарыг харав. Тэд загасчид ажээ. Есүс тэдэнд: Намайг дага. Би та нарыг хүмүүсийн загасчид болгоё гэж айлдав. Тэд тэр даруй тороо орхиж, Түүнийг дагалаа. Тэр жаахан цааш яваад Зебедеен хүү Иаков, түүнийг дүү Иохан нарыг завин дотроо тороо сэлбэж буйг харав. Тэр даруй Тэр тэднийг дуудсанд, тэд завинд эцэг Зебедеегээ хөлсний ажилчдын хамт орхиж, Есүсийг даган одоцгоолоо.

-Марк 1:16-20

Дараа өдөр нь Есүс Галил уруу явахаар завдан байхдаа Филипийг олоод, түүнд: Намайг дага гэв.

-Иохан 1:43

Дэргэдүүр нь өнгөрөнгөө,Алфайн хүү Левиг татварын газар сууж байхыг Есүс хараад, түүнд: Намайг дага гэж айлдсанд тэр босож, Түүнийг дагалаа.

-Марк 2:14

...Есүс залбирахаар ууланд гарч, бүхэл шөнийг Бурханд залбирсаар өнгөрөөв. Өглөө болоход Тэр шавь нараа Өөр уруугаа дуудаад, тэднээс арван хоёрыг сонгон, элч нар гэж нэрлэжээ.

-Лук 6:126-13

Есүс Сүнсний хүч дотор Галилд буцаж ирэв. Түүний тухай зар эргэн тойронд дахь газар тархсан байлаа. Тэр синагогуудад нь сургаал зааж эхэлсэн агаад бүгд Түүнийг магтан шагшицгааж байв. Есүс Оөрийн өссөн хот Назартаа ирж, заншсан ёсоор Амралтын өдөр синагогт орж, Судраас уншихаар босов. Түүн эш үзүүлэгч Исаиагийн номыг өргөн барив. Есүс номыг нээн доор бичигдсэн хэсгийг олоод, Эзэний Сүнс Над дээр байна. Учир нь сайн мэдээг ядууст дэлгэрүүл гэж Тэр Намайг тосолсон юм. Тэр Намайг илгээсэн нь Олзлогдогсдод эрх чөлөөг тунхаглах, Сохруудад хараа оруулах, Дарамтанд байгсдыг чөлөөлөхын сацуу, мөн Эзэний тааламжит жилийг

тунхаглахын тулд болой гэж уншаад, номоо хуйлж, харгалзагчид эргүүлэн өгөөд, суув. Синагогт байсан бүгдийн нүд Түүнийг ширтэн байлаа. Тэр тэдэнд хандаж: Энэхүү Судар өнөөдөр сонсголд тань биеялээ гэж айлдав. Бүгд Түүний тухай сайнаар ярьж, Түүний амнаас гарах нигүүслийн үгст гайхаж байв.

-Лук 4:14-22а

Тэд Иерусалимд ирцгээлээ. Есүс сүмд ороод, тэнд юм худалдаж байсан болон худалдан авч байсан хүмүүсийг хөөж эхлэн, мөнгө сольдог хүмүүсийн ширээнүүдийг, тагтаа зарж байсан хүмүүсийн сандлуудыг нь хөмнүүлж

унагаав. Есүс сурган, тэдэнд хандан: “Миний гэр бол бүх үндэстний залбирлын гэр гэж нэрлэгдэнэ” гэж бичигдээгүй гэж үү? Гэтэл та нар түүнийг дээрэмчдийн үүр болгожээ гэв.

-Марк 11:15,17

ЕСҮС ГЭМИЙН ТУХАЙ СУРГАСАН НЬ

Та нар ч гэсэн хүмүүсийн өмнө гаднаа зөвт хүмүүс мэт харагдавч, дотроо хоёр нүүрт зан болон хууль бус явдлаар дүүрэн аж.

-Матай 23:28

Харин амнаас гарах зүйл зүрхнээс гарч, тэдгээр нь хүнийг бузарладаг. Зүрхнээс хорон муу бодол, аллага, завхайрал, садар

самуун, хулгай, худал гэрчлэл, гүтгэлэг зэрэг нь гардаг.

-Матай 15:18-19

Есүс тэдэнд: Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр нүглийн боол мөн. Иймээс хэрэв Хүү та нарыг чөлөөлбөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно.

-Иохан 8:34,36

Есүс хариуд нь: Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы хаанчлалыг үзэж чадахгүй. Чи дээрээс төрөх ёстой гэж Би чамд хэлсэнд бүү гайх. Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм.

-Иохан 3:3,7,16

Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн юм.

-Иохан 10:10б

Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.

-Иохан 17:3

Учир нь Эцэг үхэгсдийг босгон, тэдэнд амь өгдөгчлөн, Хүү нь бас Оөрийн хүссэн хүнд амь өгдөг. Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь уруу шилжив.

-Иохан 5:21,24

Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун шинэ болсон байна.

-2Коринт 5:17

Ингээд тэр Самарийн Сухар гэдэг хотод ирлээ. ...Аянд ядарсан Есүс худгийн дэргэд сууж байв.Самарийн нэгэн эмэгтэй ус татахаар тэнд ирэхэд Есүс түүнээс: Надад уух юм өгөөч гэж гуйв.Өнөөх Самари эмэгтэй: Та Иудей хүн байж Самари эмэгтэй надаас яагаад уух юм гуйна вэ? гэв. Учир нь иудейчүүд самаричуудтай харьцдаггүй байжээ. Есүс түүнд Хэрэв чи Бурханы бэлгийг болон “Надад уух юм өгөөч” гэж байгаа хүн хэн болохыг мэдсэнсэн бол чи Түүнээс гуйхад Тэр чамд амийн усыг өгөх байсан гэж айлдсан. Есүс: Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. Харин өөрт нь Миний өгөх уснаас уугч хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх

аминд хүртэл оргилох булаг болно гэхэд.
-Иохан 4:5-10,13-14

....Есүс зогсоод хашгиран: Хэрэв цангасан хүн байвал, Над уруу ирж, уугтун. Надад итгэдэг хүн “Түүний дотроос усны гол урсах болно” гэж Сударт хэлсэнчлэн байх болно гэв. Есүст итгэсэн хүмүүсийн хүлээн авах Сүнсний тухай Тэр үүнийг хэлжээ.

-Иохан 7:37б-39а

Тиймд эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч аливаа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй зүйрлэгдэнэ. Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв. Эдгээр үгийг минь сонсоод, үүний дагуу үл үйлдэгч аливаа хүн элсэн дээр байшингаа барьсан мунхаг хүнтэй зүйрлэгдэнэ. Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэнд байшин хурав. Эвдрэл нь асар их байлаа гэв.

-Матай 7:24-27

Хэрэв та нарын дундаас хэн чинь зуун хоньтой байтал, нэг нь алдагдахад ерэн есөн хонио бэлчээрт орхин, алдагдсан

хонины араас явж, түүнийг олтлоо хайдаггүй вэ? Тэгээд хонио олбол, тэр баяртайгаар мөрөндөө тэгнэн, гэртээ ирээд, анд нөхдөө болон хөршүүдээ хамтад нь дуудаж, “Би алдагдсан хонио олсон тул надтай хамт баярлагтун!” гэнэ. Би та нарт хэлье. Мөн үүний адил, гэмших шаардлаггүй ерэн есөн зөвт хүнээс илүүгээр гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.

-Лук 15:4-7

Есүс олон түмнийг хараад, уул өөд гарав.Тэр амаа нээн, тэдэнд сургаж эхлэв. Сүнсэн дотроо ядуу хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал тэднийх юм. Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд тайвшрал авах болно. Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно. Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд хангалуун болох болно. Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд өршөөл энэрлийг хүртэх болно. Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханыг харах болно. Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно. Зөвт

байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй ээ! Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. -Матай 5:1-12а

....Бурханы үгийг сонсоод сахигчид нь илүү ерөөлтэй ээ! гэжээ. -Лук 11:28

....Хараагүй атлаа итгэсэн хүмүүс нь ерөөлтэй ээ! гэжээ. -Иохан 20:296

Надаас болж бүдрээгүй нэг нь ерөөлтэй ээ! -Лук 7:23

Залбирах ёстойг тэдэнд ойлгуулахын тулд Тэр ийм нэгэн сургаалт зүйрлэл айлдав. -Лук 18:16

Хоёр хүн залбирахаар сүмд оржээ. Нэг нь фарисай, нөгөө нь татвар хураагч байж гэнэ. Фарисай хүн зогсоод өөртөө залбиран “Бурхан, Танд би талархъя. Юу гэвэл би бусад хүмүүс шиг зальхай, шударга бус, завхай бишээ. Тэр байтугай энэ татвар хураагч шиг ч биш билээ. Би долоо хоногт хоёр удаа мацаг барьж, олсон бүгдийнхээ арваны нэгийг өргөдөг” гэв. Харин татвар хураагч зайдуу зогсоод, тэнгэр өөд харж ч зүрхлэлгүй, харин цээжээ дэлсэн байж, “Бурхан минь, нүгэлт намайг өршөөгөөч” гэв. Би та нарт

хэлье, фарисай нь биш, харин энэ хүн зөвтгөгдөн гэртээ харив. Учир нь өөрийгөө өргөмжилдөг аливаа хүн номхруулагдаж, өөрийгөө даруу байлгагч нь өргөмжлөгдөнө гэв.

-Лук 18:10-14

Хэрэв та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл, тэнгэр дэх Миний эцэг үүнийг нь тэдний төлөө биелүүлэх болно. Учир нь хоёр буюу гурван хүн Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав. -Матай 18:19б-20

Та нар итгэлтэйгээр залбиран гуйсан бүх зүйлээ хүлээн авах болно.

-Матай 21:22

Тэгээд Есүс шавь нартаа: Хэрэв хэн нэгэн нь Миний араас явахыг хүсвэл, тэр нь өөрийгөө үгүйсгэг. Загалмайгаа үүрч, Намайг дагаг. Учир нь хэн өөрийнхөө амийг аврахыг хүснэ, тэр хүн түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө өөрийн амийг алдана, тэр хүн түүнийгээ олно. Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ?

-Матай 16:24-26а

Иймээс та нарын хэн нь ч байгаа бүхнээсээ эс татгалзваас Миний шавь байж чадахгүй.

-Лук 14:33

Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. -Иохан 14:15

Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биенээ хайрлагтун. Энэ бол Миний тушаал.

-Иохан 15:12

Хэрэв та нар бие биенээ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно.

-Иохан 13:35

Есүс Өөрт нь итгэсэн иудейчүүдэд: Хэрэв та нар Миний үгэн дотор байвал үнэхээр Миний дагалдагчид байна.

-Иохан 8:31

Та нарын их жимс ургуулснаар Эцэг минь алдаршуулагдана. Ийнхүү та нар Миний шавь нар байх болно.

-Иохан 15:8

Намайг „Эзэн минь, Эзэн минь,, гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцгийн хүслийг биелүүлдэг хүн орно.

-Матай 7:21

...Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй.

-Матай 18:3

Нарийн хаалгаар ор. Учир нь сүйрэл уруу татан оруулдаг хаалга нь өргөн, зам нь уужим юм. Олон хүн түүгээр тийшээ ордог. Амь уруу хөтөлдөг хаалга нь жижиг, зам нь нарийн юм. Цөөхөн хүн түүнийг олдог.

-Матай 7:13-14

Энэ үеийн төгсгөл ч мөн ийм байх болно. Тэнгэр элч нар ирж, зөвт хүмүүсийн дундаас муу хүмүүсийг ялгаж, тэднийг галтай зууханд хаяна. Тэнд тэд уйлж, шүдээ хавирах болно.

-Матай 13:49-50

Та нар зүрхээ бүү зовоо. Бурханд итгэ, мөн Надад итгэ. Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Хэрэв тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно.

-Иохан 14:-1-3

Би бол тэнгэрээс бууж ирсэн амьд талх байна. Хэрэв хэн нэгэн энэ талхнаас идвэл, тэр мөнхөд амьдарна. Ертөнцийн амийн төлөө Миний өгөх талх бол Миний махан бие юм гэж айлдлаа.

-Иохан 6:51

Би бол үүд мөн. Хэрэв хүн Надаар орвол, тэр аврагдах болно. Орж гарч тэжээлээ олно. Би бол сайн хоньчин мөн. Сайн хоньчин хоньдынхоо төлөө амиа өгдөг.

-Иохан 10:9,11

Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

-Иохан 14:6

Би бол ертөнцийн гэрэл мөн. Намайг дагадаг хүн харанхуй дотор явахгүй, харин амийн гэрэлтэй болно гэж айлдав.

-Иохан 8:126

Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна.

-Иохан 11:256

Та нар Намайг Багш, Эзэн гэж дууддаг. Та нар зөв ярьж байна. Учир нь Би үнэхээр мөн.

-Иохан 13:13

Тэд бүгд: Чи тэгээд Бурханы Хүү юм уу? гэсэнд Тэр тэдэнд, Би мөн гэдгийг та нар хэлж байна гэв.

-Лук22:70

Уяман өвчтэй нэгэн хүн Түүн дээр ирээд, өмнө нь сөгдөж, Эзэн минь, хэрэв Та хүсвэл намайг цэвэр болгож чадна шүү дээ гэхэд, Есүс гараа сунган түүнд хүрч, Хүсэж байна. Цэвэрш гэв. Тэр даруй түүний уяман өвчин нь цэвэршжээ.

-Матай 8:2-3

Үзэгтүн, сүнснээс болж арван найман жилийн турш өвчтэй байсан нэгэн эмэгтэй тэнд байв. Тэр бөгтгөр болсон учир ер цэх зогсож чаддаггүй байжээ. Есүс түүнийг хараад дуудаж: эмэгтэй, та өвчнөөсөө чөлөөлөгдлөө гээд түүн дээр мутраа тавихад, даруй тэр дахин цэх болж, Бурханыг алдаршуулж эхлэв.

-Лук 13:11-13

Маш олон хүн Түүн дээр доголлон, тахир дутуу, сохор, дүлий болон олон хүнийг авч ирээд хөл дор нь тавилаа. Тэр тэднийг эдгээв.

-Матай 15:30

Симоны хадам эх халуураад хэвтэж байлаа. Тэр даруйд тэд түүний тухай Есүст хэлэхэд Тэр түүн уруу ирээд гараас нь барин босгоход тэр эмэгтэй халуурахаа болиод, тэдэнд үйлчилжээ.

-Марк 1:30-31

Есүс хурсан олонд зүлэг ногоон дээр суухыг тушаагаад таван талх, хоёр загасыг авч, тэнгэр өөд ширтэж, хүнсийг ерөөгөөд талхаа хувааж шавь нартаа өгөв. Шавь нар нь хурсан олонд өгөхөд тэд бүгд идэж, цаджээ. Тэгээд тэд үлдэгдэл өвдөл цөвдлийг нь цуглуулахад арван хоёр сагс дүүрэв. Тэнд эмэгтэйчүүд, хүүхдүүдээс гадна таван мянга орчим эрчүүд байж идсэн ажээ.

-Матай 14:19-21

Шөнийн дөрөвдүгээр манааны үед Тэр нуурын дээр алхан тэднийг зүглэн ирж явав. Нууран дээр алхаж яваа Түүнийг хараад шавь нар нь сандарч, Энэ чинь хий үзэгдэл байна гээд айснаасаа болж

хашхиралдав. Харин тэр даруй Есүс тэдэнд зоригтой бай. Би байна. Бүү ай гэжээ.

-Матай 14:25-27

Тэнд хүчит салхи үүсэж, давалгаа завийг хөмрөн ирж, завь хэдийнээ усанд автжээ. Есүс завины хэтэгт дэр дэрлээд унтаж байлаа. Шавь нар нь Түүнийг сэрээж, Түүнд: Багш аа, бидний үхэх нь Танд хамаагүй гэж үү? гэлээ. Есүс сэрээд салхийг буруушааж, нуурт: Чимээгүй. Намд гэж айлдав. Салхи зогсож, шуурга бүр нам гүм болов.

-Марк 4:37-39

Харин Хүний Хүү газар дээр нүглийг уучлах эрх мэдэлтэйг та нарт мэдүүлэхийн тулд гээд, Тэрээр саа өвчтэй хүнд: Бос, дэвсгэрээ аваад гэртээ харь гэсэнд, мөнөөх хүн босож гэрийн зүг явлаа.

-Матай 9:6-7

Эмэгтэйд: Нүгэл чинь уучлагдсан гэлээ. Түүний хамт тухлан сууж байсан хүмүүс хоорондоо Нүглүүдийг хүртэл уучилдаг энэ хүн хэн гээч вэ? гэлшлээ.

-Лук 7:48-49

Иймд ах дүү нар аа, та нар үүнийг мэдэгтүн. Түүгээр дамжуулан нүглийн уучлал та нарт тунхаглагдаж байна. Итгэсэн хүн бүр Мөсэгийн хуулиар

зөвтгөгдөж чадаагүй тэр бүхнээсээ Түүгээр зөвтгөгдөх болно.

-Үйлс13:38-39

Түүний нигүүлслийн баялгийн дагуу Түүний дотор цусаар нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бидэнд байдаг.

-Эфэс 1:7

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэсжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.

-1Иохан 1:9

Синагогт бузар чөтгөрийн сүнсэнд эзэмдүүлсэн нэгэн хүн байсан агаад тэр чанга дуугаар: Хүүе, Назарын Есүс ээ, бид Танд ямар хамаатай билээ? Та биднийг хөнөөхөөр ирсэн үү? Би Таны хэн болохыг, Бурханы Ариун Нэгэн гэдгийг мэднэ гэхэд Есүс түүнийг зэмлэж, Дуугүй бай. Түүнээс зайл! гэлээ. Тэгтэл чөтгөр түүнийг хүмүүсийн дунд унагаагаад, хөнөөлгүйгээр түүнээс гарч одов. Тэд бүгдээрээ гайхширч, өөр хоорондоо энэ юун сургаал вэ? Тэр эрх мэдэл хийгээд хүчээр бузар сүнснүүдэд тушаахад тэд гарцгаав гэж ярилцаж эхлэн.

-Лук 4:33-36

Ойртон ирэх зуур нь чөтгөр түүнийг газар унагахад хүү татвалзаж гарав. Гэвч Есүс тэр бузар сүнсийг зэмлээд, хүүг эдгээж, эцэгт нь эргүүлэн өгөв. Бурханы агууг бүгд бахдан байлаа.

-Лук 9:42-43а

Энэ нь Назарын Есүсийн тухай бөгөөд Бурхан хэрхэн Түүнийг Ариун Сүнс ба хүч чадлаар тослосон хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан.

-Үйлс 10:38

Есүс: Хадыг зайлуул гэхэд талийгаачийн дүү Марта Түүнд: Эзэн, тэр үхээд дөрөв хонож байгаа тул одоо өмхий үнэр орсон байгаа гэж хэлэв. Есүс Мартад “Хэрэв чи итгэвэл Бурханы алдрыг харна” гэж Би чамд хэлээгүй бил үү? гэлээ. ...Тэр ийн айлдаад, чанга дуугаар: Лазар, гараад ир гэж хашхирав. Үхсэн хүн гар, хөл нь оршуулгын боолттой, нүүр нь алчуураар ороолттой чигээрээ гарч ирэв. Есүс тэдэнд: Тайлж, түүнийг явуул гэв.

-Иохан 11:39-40, 43-44

Түүний өмнө мөргөөд,-Миний охин дөнгөж саяхан үхчихлээ. Харин Та очиж түүнд гар хүрвэл охин минь амьдрах болно гэжээ. Тэднийг гарсны дараа Есүс

дотогш орж, охины гараас барихад охин босов.

-Матай 9:186,25

Түүнийг хотын хаалганд ойртон ирэх үед хүмүүс нэг үхсэн хүнийг аваад гарч явав. Тэр нь бэлэвсэн эмэгтэйн ганц хүү байсан бөгөөд хотынхноос нилээд олон хүн тэр эмэгтэйн хамт байв. Эзэн түүнийг хараад ихэд өрөвдөн түүнд: Бүү уйл гэв.Тэр очоод авсанд гараа хүргэтэл өргөөд явж байсан хүмүүс зогслоо. Тэгээд Есүс: Би чамд хэлж байна. Залуу минь, бос! гэхэд үхсэн хүн босоод ярьж эхлэв.

-Лук 7:12-15a

Есүс Цезарь Филипийн нутагт очих үедээ шавь нараасаа: Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна? гэж асуув. Тэгэхэд нь тэд: Зарим нь баптисм хүртээгч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл эш үзүүлэгчдийн нэг гэж ярьдаг гэхэд, Тэр: Харин та нар Намайг хэн гэж хэлэх вэ? гэсэнд Симон Петр: Та бол Христ, амьд Бурханы Хүү мөн гэв. Есүс түүнд хариуд нь: Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус нь биш, харин тэнгэр дэх Миний Эцэг илчилсэн юм.

-Матай 16:13-17

Тэдний олонх нь: Түүнд чөтгөр шүгэлж. Тэр солиотой юм. Та нар юунд

Түүнийг сонсоно вэ? гэлээ. Зарим нь: Эдгээр үгс нь чөтгөр шүглэсэн хүнийх биш. Чөтгөр сохрын нүдийг нээж чадах уу? Хэмээн ярьж байлаа.

-Иохан 10:20-21

Мариагийнд ирсэн иудейчүүдээс олон хүн Есүсийн хийсэн зүйлийг хараад, Түүнд итгэжээ. Харин тэдний зарим нь фарисайчууд уруу очиж, Есүсийн хийсэн зүйлийг тэдэнд хэлцгээв. Энэ өдрөөс тэд Есүсийг алахаар төлөвлөв.

-Иохан 11:45-46, 53

“Тэд шалтгаангүйгээр Намайг үзэн ядсан.”

-Иохан 15:25а

ЕСҮС ӨӨРИЙН ҮХЭЛ БА ДАХИН АМИЛАЛТЫН ТУХАЙ УРЬДЧИЛЖ ХЭЛСЭН

Тэр тэдэнд Хүний Хүү их зовов ёстойг болон ахлагчид болон ахлах тахилч нар, хуулийн багш нарт ад үзэгдэж алуулаад гурав хоногийн дараа дахин амилах тухай зааж эхлэв.

-Марк8:31

Хэрэв Би газраас өргөгдвөл, бүх хүнийг Өөртөө татна хэмээн айлдлаа. Тэр өөрөө ямар үхлээр үхэхээ онцолж үүнийг хэлжээ.

-Иохан 12:32-33

Есүс тэдэнд: Энэ сүмийг устга. Би үүнийг гурван өдрийн дотор босгоно гэсэнд иудейчүүд: Энэ сүмийг барихад дөчин зургаан жил шаардагдсан байтал,

үүнийг Та гурван өдрийн дотор босгоно гэж үү? гэв. Гэтэл Есүс Өөрийн биеийн сүмийн тухай айлдсан ажээ. Тэгээд Есүсийг үхэгсдээс амилахад үүнийг Тэр айлдсаныг шавь нар нь санаж, Судар болон Есүсийн айлдсан үгэнд итгэцгээв.

-Иохан 2:19-22а

Иона далайн мангасны гэдсэнд гурван өдөр, гурван шөнө байсанчлан Хүний Хүү газрын зүрхэнд гурван өдөр гурвөн шөнө байх болно.

-Матай 12:40

Харин Би амилуулагдсаны дараа та нараас өмнө Галилд очно гэв.

-Матай 26:32

Маргааш нь баярт ирсэн үй олон хүн Есүсийг Иерусалим уруу ирж явааг сонсоод далдуу модны мөчрийг барьж, Түүнийг угтахаар гарч, -Хосанна? Эзэний нэрээр Ирэгч, Израилийн Хаан ерөөлтэй еэ? гэж хашхиралдаж байлаа. Есүс залуу илжиг олж унасан байв. Энэ нь Сионы охин оо, бүү ай? Харагтун, Хаан чинь илжигний дудран унаад ирж байна гэж бичигдсэнчлэн болов.

-Иохан 12:12-15

Есүсийг иерусалимд ороход олон хүн Түүнийг баяр хөөртэйгээр угтаж авсан боловч, Есүс Түүний хүмүүс Түүнийг эсэргүүцнэ гэдгийг мэдэж байсан. Тэр Иерусалимд тохиолдох зүйлийн талаар бодоод харамсан гашуудсан.

Яагаад гэвэл тэд өөрсдөд нь амар тайвныг авчирах цорийн ганц Нэгэнийг хүлээж аваагүй.

Тэгээд Есүс ойртон ирж хотыг хараад түүний төлөө уйлж. Хэрэв чи энэ өдөр амар тайванд юу хүргэхийг мэдсэнсэн бол! Харин эдүгээ энэ нь нүднээс чинь далдлагдав. Дайснууд чинь чиний эсрэг бэхлэлт босгон чамайг бүсэлж, тал талаас чинь бүчих өдрүүд ирэх үед чамайг болон чиний дотор хүүхдүүдийг чинь газартай тэгшлэх болно. Тэд чиний дотор чулууг чулуун дээр нь орхихгүй. Учир нь чам дээр Бурханы ирсэн цагийг чи мэдээгүй юм гэв.

-Луух 19:41-44

Дараа өдөр нь Иохан өөр уруу нь ирж яваа Есүсийг хараад-Ертөнцийн нүгэлийг үүрэгч Бурханы Хургыг харагтун!

-Иохан 1:29

Дээгүүр Онгөрөх баярын хургыг нядлах Исгээгүй Талхны Баярын эхний өдөр болов. Тэр талх авч, талархал өргөөд тэдэнд хуваан өгөхдөө -Энэ бол та нарын төлөө өгөх Миний бие мөн. Намайг дурсаж үүнийг үйлд гэж айлдав. Тэр аяга авч, талархал өргөөд, аягаа тэдэнд өгөв. Тэд цөмөөрөө түүнээс уулаа.

-Луух 22:7-8, 19, Маарх 14:23-24

Тэр тамлагдсан, зовсон боловч амаа нээсэнгүй. Алагдахаар хөтлөгдөх хурга

шиг, хяргагчийн өмнө дуугарахгүй хонь шиг Тэр амаа нээсэнгүй. -Исаиа 53:7

Та нар исгэгдээгүй юм шиг шинэ зуурсан гурил байхын тулд хуучин хөрөнгийг бүрмөсөн цэвэрлэ. Учир нь бидний Дээгүүр Онгөрөх баярын хурга болох Христ ч гэсэн тахил болсон юм.

-I Коринт 5:7

Ингэхдээ та нар эцэг өвгөдөөсөө өвлөсөн өөрсдийн утгагүй амьдралаас алт, мөнгө мэтийн устах зүйлсээр золигдсон бус. Харин үнэт цусаар, Христийн цус болох гэм зэмгүй бөгөөд тологгүй хурганы цусаар золигдсон гэдгээ мэдэгтүн.

-I Пэтр 1:18-19

Арван хоёрын нэг байсан Искарриотын Иудас Есүсийг барьж өгөхийн тулд ахлах тахилч нар уруу явлаа. Тэд үүнийг сонсоод, баярлаж түүнд мөнгө өгнө гэж амлав. Боломжтой цагт Есүсийг яаж барихыг тэр эрэлхийлж эхлэв.

-Маарх 14:10-11

Есүс тэдний хамт Гетсемани хэмээх нэрлэдэг газар ирж, шавь нартаа: Намайг тэнд очиж залбирах зуур энд сууцгааж байгээд, Тэр өөрийн хамт Пэтр болон Зебедеен хоёр хүүг авч явав. Тэр зовж, шаналж эхлэв. Тэр тэндээс жаахан цаашаа яваад, нүүрээрээ унаж-Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш,

харин Таны хүслээр болог гэж залбирлаа.
-Матай 26:36-39

Тэгтэл Иудас цэргийн баг, ахлах тахилч нар болон фарисайчуудаас харуулуудыг нь дагуулж ирэв. Тэд дэнлүү, бамбар, зэвсэг барин хүрч ирлээ. Иигээд баг цэрэг, мянгатын дарга болон иудейчүүдийн харуулууд Есүсийг барьж хүлээд...

-Иохан 18:3,12

Ахлах тахилч нар хийгээд бүх Зөвлөл Есүсийг алахын тулд Түүний эсрэг гэрчлэхийг хичээсэн боловч юу ч олсонгүй. Учир нь олон хүн Есүсийн эсрэг хуурамч гэрчлэл өгсөн боловч, гэрчлэлүүд нь таарахгүй байлаа.

-Маарх 14 :55-56

Өглөө эрт ахлагч тахилч нар болон олны ахлагчид Есүсийг алуулахаар зөвлөлдөөд, Түүнийг хүлж, авч яваад захирагч Пилатад тушаав. Тэгтэл Пилат Тэгвэл Христ гэгдэх Есүсийг би яах болж байна? гэсэнд тэд бүгд л Түүнийг цовдол гэцгээв.

-Матай 27:1-2,22

Тэд Түүнийг цовдлох үед гуравдугаар цаг байсан юм. Ялынх нь цайзан дээр “Иудейчүүдийн Хаан” гэж бичсэн байлаа. Цэргүүд Есүстэй хамт хоёр дээрэмчнийг, нэгийг нь баруун талд нь, нөгөөг нь зүүн талд нь цовдолжээ. “Тэр хилэнцэтнүүдийн хамт тоологдсон” гэсэн Судар биелэгдэв. Түүгээр өнгөрөн явагсад Есүсийг

басамжлан доромжилж, толгойгоо сэгсрэн -Өө! Сүмийг устгаад гурван хоногт дахин баригч Та Өөрийгөө авраач! Наад загалмайнаасаа буугаач гэж байлаа. Мөн түүнчлэн ахлах тахилч нар хуулийн багш нарын хамт Түүнийг элэглэн дооглож, өөр хоорондоо Тэр бусдыг аварсан. Тэр Өөрийгөө аварч чадахгүй.

-Маарх 15:25-31

Есүс: Аав аа, Таны гарт Би сүнсээ даатгая гэж чанга дуугаар хашхирлаа Үүнийг хэлээд Тэр амьсгалаа хураав.

-Луух 23:46

Зургадугаар цагаас есдүгээр цаг хүртэл бүх газрыг харанхуй нөмрөн авлаа. Есүс дахин чангаар хашхираад Өөрийн сүнсээ гаргажээ. Үзэгтүн, сүмийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон цуу урагдаж, газар хөдлөн, хад чулуу бут хагаран, Есүсийг харгалзаж байсан зуутын дарга болон харуулууд газар хөдлөлт болон болж буй бүхнийг хараад ихэд айн -Үнэхээр энэ хүн Бурханы Хүү байжээ гэв. -Матай 27:45, 50-51,54

Цэргүүд ирж, Есүстэй хамт цовдлогдсон эхний хүний болон нөгөө хүнийх нь хөлийг хугалав. Харин Есүс уруу ирээд Түүний хэдийнээ үхсэн байхыг тэд үзээд, хөлийг нь хугалсангүй.

Цэргүүдийн нэг нь Түүнийг хажуу уруу нь жадлахад цус, ус гоожлоо. Харсан хүн нь үүнийг гэрчлэв. Түүний гэрчлэл нь үнэн бөгөөд та нарыг ч мөн итгүүлэхийн тулд үнэн ярьдаг гэдгээ тэр мэднэ. Судрын Түүний нэг ч яс хугалагдахгүй гэсэн нь биелэгдэхийн тулд эдгээр нь болжээ. Тэд жадласан Хүн уруугаа харах болно. Гэж мөн өөр Сударт хэлдэг.

-Иохан 19:32-27

Ариун агаад зөвт Нэгэнийг та нар үгүйсгэсэн атлаа алуурчныг өршөөхийг гуйсан боловч үхэгсдээс Бурханы босгосон амийн Зохиолчийг алуулсан билээ. Үүний гэрч нар нь бид юм.

-Үйлс 3:14-15

Дараа өдөр нь бэлтгэлийн өдрийн дараахь өдөр байсан бөгөөд ахлах тахилч нар болоод фарисайчууд Пилатынд цуглаж, Эрхэм ээ, тэр мэхлэгч амьд байхдаа “Би гурав хоногийн дараа амилна” гэж хэлж байсныг бид санаж байна. Тиймээс шавь нар нь ирж Түүнийг хулгайлан аваад ард олонд “Тэр үхэгсдээс амилав” гэж хэлүүлэхгүйн тул гурав дахь өдөр нь хүртэл булшийг хамгаалахыг тушаагаач. Хэрэв тэгэхгүй бол сүүлчийн мэхлэлт нь эхнийхээсээ ч дор муу юм болно гэгцгээлээ. Пилат тэдэнд: Харуул аваад яв, хэрхэн хамгаалахаа та нар өөрсдөө мэдэж байгаа биз дээ гэв. Тэд очоод хадан дээр лац тавьж, харуул гарган булшийг манацгаав. -Матай 27:62-66

Амралтын өдрийн дараа долоо хоногийн эхний өдөр үүрээр Магдалын Мариа болон нөгөө Мариа нар булшийг үзхээр ирэв. Харагтун. Маш хүчтэй газар хөдлөлт болжээ. Учир нь Эзэний тэнгэр элч тэнгэрээс буун ирж чулууг зайлуулаад дээр нь суужээ. Түүний дүр аянга лугаа адил хувцас нь цас шиг цагаан байв. Харуулууд түүнээс айн чичирч, үхсэн мэт болжээ. Тэгтэл тэнгэр элч эмэгтэйчүүдэд Бүү ай. Загалмайд цовдлогдсон Есүсийг хайж байгааг чинь би мэдэж байна. Тэр энд байхгүй. Учир нь хэлж байснаараа Тэр амилсан. Ирэгтүн Түүний хэвтэж байсан газрыг үзэгтүн.

-Матай 28:1-6

Оршуулагдан, Сударын дагуу гурав дахь өдөртөө амилуулагджээ.

-1Коринт 15:4

Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би Өөрийн амийг буцааж авахын тулд амиа өгнө. Хэн ч Миний амийг Надаас авахгүй. Харин Би Өөрийн санаагаар түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм гэв.

-Иохан 10:17-18

Тэр үхлийг мөнхөд залгина. Эзэн Бурхан бүх нүүрнээс нулимсыг арчина.

-Исаиа 25:8а

Амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Харагтун, Би үеийн үед амьд байна. Надад үхэл ба Үхэгсдийн орны түлхүүр бий.

-Илчлэлт 1:18

Үхэл ээ, чиний ялалт хаана байна вэ? Үхэл ээ, чиний хатгуур хаана байна вэ? Харин бидний Эзэн Есүс Христээр бидэнд ялалтыг өгдөг Бурханд талархал нь байх болтугай.

-1Коринт 15:55,57

Үүнд бүү гайхагтун: Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон, гарч ирэх цаг ирж байна. Сайн үйлсийг үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, мууг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ.

-Иохан 5:28-29

Долоон хоногийн эхний өдөр Тэр эрт амилаад, эхлээд Магдалын Мариад үзэгджээ. Есүс Мариад шүглэсэн долоон чөтгөрийг зайлуулсан юм. Үүний дараа тэдний хоёр нь хөдөө явж байтал замд нь Есүс Оөрийгөө өөр дүрээр тэдэнд үзүүлэв.
-Марк 16:9,12

Долоон хоногийн эхний өдөр буюу тэр өдрийн үдэш, шавь нар нь иудейчүүдээс айснаас хаалгаа түгжсэн байв. Гэтэл Есүс ирээд тэдний дунд зогсож, тэдэнд: Амар амгалан та нартай хамт байх болтугай гэв. Үүнийг айлдаад, Тэр тэдэнд гар, хажуугаа үзүүлэв. Шавь нар нь Эзэнийг хараад ихэд баярлав.
-Иохан 20:19-20

Тэрээр Кефт, дараа нь өнөөх арван хоёрт үзэгдэв. Үүний дараа Тэр таван зуу гаруй ах дүү нарт нэг мөчид үзэгдсэн бөгөөд одоо болтол тэдний олонх нь амьд байна. Харин зарим нь нойрсжээ. Дараа нь Тэр Иаковд, тэгээд бүх элч нарт үзэгдсэн.

-1 Коринт 15:5-7

Бурхан Түүнийг гурав дахь өдөр нь амилуулж, бүх хүмүүст биш, харин Бурханаар урьд нь сонгогдсон гэрчлэгчдэд буюу үхэгсдээс амилсных нь дараа Түүнтэй идэж, ууж байсан бидэнд харуулан соёрхов.

-Үйлс 10:40-41

ЕСҮС ӨӨРИЙН ДАГАЛДАГЧИДДАА ЗАХИРАМЖ ӨГӨӨД ТЭНГЭР ӨӨД ОДЛОО

39

Есүс дахин тэдэнд: Амар амгалан та нартай хамт байх болтугай. Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ гэв. Үүнийг айлдаад, Тэр тэдэн уруу үлээн: Ариун Сүнсийг хүлээн авагтун гэв.

-Иохан 20:21-22

Есүс ойртон ирээд, тэдэнд: Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс, явж бүх улс үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт. тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав. -Матай 28:18-20

Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв. Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов.

-Үйлс 1:8-9

Ингээд Эзэн Есүс тэдэнд айлдсаны дараа тэнгэр өөд авагдаж, Бурханы баруун гарт залрав. Тэд явж, газар сайгүй тунхаглажээ. Эзэн тэдэнтэй хамт ажиллаж, үгийг дагалдах тэмдгүүдээр баталж өгчээ.

-Марк 16:19-20

Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээн авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна. Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ.

-Иохан 14:16-18

Пентекостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газарт цугласан байлаа. Гэнэт тэнгэрээс хүчит хуй салхи мэт дуу чимээ гаран, тэдний сууцгөөж байсан байр бүхэлдээ тэрхүү дуунд автагджээ.

Тэгтэл гал хаялах мэт хэлүүд бий болон хүн нэг бүрийн дээр тогтохыг тэд харлаа. Ийнхүү тэд бүгд Ариун Сүнсээр дүүрч, мөнөөх Сүнсээр дамжуулан өгөгдсөнийг харь хэлээр ярьж эхлэв.

-Үйлс 2:1-4

Энэ Есүсийг Бурхан амилуулсан бөгөөд бид бүгдээрээ үүний гэрч нар мөн. Тиймээс Бурханы баруун гарт өргөмжлөгдөж, Эцэгээс амласан Ариун Сүнсийг аваад, Тэр та нарын үзэж, сонсоцгоож байгааг цутгасан юм.

-Үйлс 2:32-33

Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй. -Иохан 15:4-5

Түүний тушаалуудыг сахигч нь Түүний дотор байж, Тэр түүний дотор байна. Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр дамжуулан бид үүгээр мэддэг. -1Иохан 3:24

Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор

Христ амьд байна. Эдүгээ би махан биендээ амьд байгаа нь намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө тушаасан Бурханы Хүүд итгэх итгэлээр амьдарч буй хэрэг юм.

-Галат 2:20

Тэр Өөрийн алдрын баялгийн дагуу Өөрийн Сүнсээр дамжуулан хүч чадлаар та нарын доторх хүнийг хүчтэй болгон соёрхох болтугай. Ингэж итгэлээр Христ та нарын зүрхэнд нутаглаж, та нар хайр дотор үндэслэж суурьлав. -Эфэс 3:16-17

Махан бие дотор байгсад Бурханд таалагдаж чадахгүй. Хэрэв Бурханы Сүнс үнэхээр та нарын дотор оршиж байвал, та нар махан бие дотор бус, харин Сүнс дотор байна. Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш. -Ром 8:8-9

Бурханы нигүүлслээр хүн бүрийн төлөө үхлийг амсахын тулд тэнгэр элч нараас арай дорд болгогдсон бөгөөд үхлийн зовлонгийн учир цог жавхлан хийгээд хүндэтгэлийн титэм өмссөн Есүсийг бид хардаг.

-Еврей 2:9

Учир нь Түүнийг Эцэг Бурханаас хүндлэл ба алдрыг хүлээн авах үед Сүр Жавхлант Алдраас: “Энэ бол Миний хайртай Хүү. Түүнд Миний таалал оршино” гэсэн дуу гарав. Бид Түүнтэй хамт ариун уулан дээр байхдаа тэнгэрээс гарсан энэ дууг сонссон билээ.

-2Петр 1:17-18

Дэнлүүний сууриудын дунд, хөлдөө хүрсэн урт дээл өмссөн, цээжээрээ алтан бүс бүсэлсэн Хүний Хүү шиг Нэгэн байлаа. Түүний толгой, үс нь цагаан ноос мэт, цас мэт цав цагаан бөгөөд нүд нь галын дөл мэт, хөл нь зууханд улайсгаад өнгөлсөн хүрэл мэт, дуу хоолой нь их усны шуугиан мэт байлаа. Тэр баруун мутартаа долоон од барьжээ. Түүний амнаас хоёр талдаа хурц иртэй илд цухуйх бөгөөд нүүр нь өөрийн хүчээр гэрэлтэх нар мэт байлаа. Би Түүнийг хармагцаа үхсэн хүн шиг хөлд нь уналаа. Тэр баруун мутараа над дээр тавьж: Бүү ай. Би бол эхэн ба эцэс бөгөөд амьд Нэгэн мөн гэв.

-Илчлэлт 1:13-17

Харин Надад чиний эсрэг зүйл байна.
 Юу гэвэл чи анхны хайраа орхижээ.
 Тиймээс чи хаанаас унаснаа санаж гэмш...
 -Илчлэлт 2:4-5а

Эдлэх гэж буй зовлонгоосоо бүү ай.
 Үзэгтүн, диавол та нарыг сорихын тулд та
 нараас заримыг чинь шоронд хаях гэж
 байна... Үхэх хүртэл итгэмжтэй бай.
 Тэгээд Би чамд амийн титмийг өгнө.
 -Илчлэлт 2:10

Энэ мэт ялагч нь цагаан хувцас
 өмсөнө. Би түүний нэрийг амийн номноос
 баллахгүй. Би Оөрийнхөө Эцэгийн өмнө
 болоод Түүний тэнгэр элч нарын өмнө
 түүний нэрийг хүлээн зөвшөөрнө.
 -Илчлэлт 3:5

...Харагтун, хэн ч хааж үл чадах
 нээлттэй хаалгыг Би чиний өмнө тавьсан.
 Юу гэвэл чиний хүч бага бөгөөд чи
 Миний үгийг сахиж, Миний нэрийг
 үгүйсгээгүй билээ. -Илчлэлт 3:8б

Тийнхүү чи халуун ч биш, хүйтэн ч
 биш, бүлээвтэр тул Би чамайг амнаасаа
 бөөлжиж гаргана. -Илчлэлт 3:16

Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг,
 сахилгажуулдаг юм. Тиймээс зүтгэлтэй
 бай, гэмш. Би ялж, Эцэгийнхээ хамт
 Түүний сэнтийнд заларсны адил Надтай
 хамт Миний сэнтийнд залрахыг ялагчид
 соёрхоно. -Илчлэлт 3:19, 21

Харин Тэр үүрд нүглийн төлөө нэг тахилыг өргөөд, Бурханы баруун гарт заларсан. -Еврей 10:12

Иймээс бидэнд тэнгэрт заларсан агуу Тэргүүн Тахилч болох Бурханы Хүү Есүс байгаа тул өөрсдийн хүлээн зөвшөөрдгөө бат баримталъя. Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцаж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ. Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё. -Еврей 4:14-16

Гэтэл нөгөө талаас Тэр мөнхөд байдаг тул Оөрийн тахилчийн үүргийг байнга барьдаг. Тиймээс Тэр Оөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай. Учир нь Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг. -Еврей 7:24-25

Учир нь Тэр Оөрөө “Би чамайг хэзээч орхихгүй. Би чамайг хэзээ ч мартахгүй” гэж айлдсан. Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч мөн. Би айхгүй. Хүн намайг яах юм бэ?” гэдэг. -Еврей 13:5б-6

Есүс Христ өчигдөр ч, өнөөдөр ч хэвээрээ бөгөөд мөнхөд хэвээрээ байна. -Еврей 13:8

Хэрэв Би явж та нарт орон байр бэлдвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно.
-Иохан 14:3

Учир нь Эзэн Өөрөө тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрэн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно. Дараа нь амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно.
-1 Тесалоник 4:16-17

Аянга зүүн зүгээс цахиж, баруун зүгт ч гялбуулдаг шиг, Хүний Хүүгийн заларч

ирэх нь тийм байх болно. Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дээр сүр хүч болоод агуу цог жавхлантайгаар ирэхийг харна. Тэр тэнгэр элч нараа их бүрэн дуугаар илгээхэд тэд сонгогдогсдыг нь тэнгэрийн нэг хязгаараас нөгөө хязгаар хүртэл дөрвөн салхинаас цуглуулах болно.

-Матай 24:27, 30-31

Учир нь Хүний Хүү тэнгэр элч нарын хамт Эцэгийнхээ алдрын дотор ирж, хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгнө.

-Матай 16:27

Иймээс ч Бурхан харанхуй балар үеийг харалгүй өнгөрөөсөн. Харин эдүгээ хаа сайгүй хүн бүхэн гэмших ёстойг Тэр хүмүүст хандан тунхаглаж байна. Оөрийнхөө томилсон нэгэн Хүнээр дамжуулж ертөнцийг шударгаар шүүх өдрөө Тэр тогтоосон агаад тэр Хүнийг үхэгсдээс амилуулснаар үүнийгээ бүх хүмүүст нотолсон ажгуу хэмээв.

- Үйлс 17:30-31

Тэр өдөр Надад олон хүн “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” гэж хэлэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг огт

танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ.

-Матай 7:22-23

Гэвч Эзэний өдөр нь хулгайч мэт ирэх болно. Тэгэхэд тэнгэр нүргэлээд өнгөрнө. Аливаа бодисууд нь галд устгагдах бөгөөд газар болоод түүн дээрх ажлууд нь шатаагдана. Хэрэв энэ бүхэн тийн устгагдах аваас ариун байдал ба бурханлаг байдал дотор та нар ямар төрлийн хүмүүс байх ёстой вэ? Бурханы өдрийн ирэхийг хүлээж, түргэлүүл. Тэр өдөр тэнгэр шатан устаж, халуун илчинд нь бодисууд хайлах болно. Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна. -2Петр 3:10-13

Тиймээс ч Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн бөгөөд аливаа нэрнээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмс өвдөг сөгдөж, мөн бүх хэл Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрөх ёстойн учир ажээ. -Филиппой 2:9-11

Би шөнийн үзэгдлийг харсаар байсан бөгөөд, Харагтун, Хүний Хүү шиг Нэгэн тэнгэрийн үүлсийг хөлөглөн ирж, Тэрээр Эртний Нэгэнд очоод, Түүнд бараалхав. Түүнд эрх мэдэл, сүр жавхлан ба хаанчлал өргөгдөж, Бүх ард түмэн, үндэстэн, бүх хэлтэн Түүнд үйлчлэв. Түүний ноёрхол

үүрдийн ноёрхол бөгөөд өнгөрөн одохгүй. Түүний хаанчлал нь устахгүй хаанчлал юм. -Даниел 7:13-14

Нядлуулсан Хурга хүч, баялаг, мэргэн ухаан, сүр хүч, хүндэтгэл, алдар ба магтаалыг авбал зохистой. -Илчлэлт 5:12

Ертөнцийн хаанчлал нь бидний Эзэний болон Түүний Христийн хаанчлал болсон. Тэр үеийн үед хаанчилна. -Илчлэлт 11:15

Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье. Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд Та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

-Матай 11:28-29

Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.

-Илчлэлт 3:20

Эзэн удаашралыг тооцдог зарим хүмүүсийн боддог шиг Оөрийнхөө амлалтад хойрго биш билээ. Харин ч Тэр

хэнийг ч мөхүүлэхийг хүсэлгүй, бүгдийг гэмшилд ирээсэй хэмээн хүсэн та нарт тэвчээртэй ханддаг.

-2Петр 3:9

Эцэгийн Надад өгдөг бүхэн Над уруу ирнэ. Над уруу ирэх хүнийг Би огт хөөж гаргахгүй.

-Иохан 6:37

Эзэний нэрийг дуудсан бүхэн аврагдах болно.

-Үйлс 2:21

...Одоо бол авралын өдөр байна.

-2Коринт 6:2

Ирээрэй гэж хэлэг. Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг.

-Илчлэлт 22:17б

ТА ЕСҮС ДОТОР ЮУ ХИЙХ ВЭ?

Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдаг. -Иохан 3:36

Бид нийм авралыг үл хайхраад хэрхэн зугтаах билээ? -Еврей 2:3а

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. -Иохан 1:12

Тиймээс та нар бүх бузар байдал, хорон санааныхаа бүх л үлдэгдлийг хажуу тийш нь тавьж, өөрсдийн чинь дотор суулгагдсан үгийг даруухнаар хүлээж авагтун. Тэр үг та нарын сэтгэлийг аврах чадалтай. -Иаков 1:21

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрөн авралд хүрнэ. -Ром 10:9-10

ЗАЛБИРЛЫН ХӨТӨЧ

Их Эзэн Есүс минь ээ,

Миний гэмийг авахын тулд загалмай дээр цовдлогдон нас барсанд чинь баярлалаа. Миний хийсэн буруу зүйлүүдийг уучлаач. Би Таныг зүрх сэтгэлдээ яг одоо миний аврагч Эзэн гэж хүлээн авч байна. Би Таны намайг Бурханы хүүхэд болгох амлалтанд чинь итгэж байна. Би Таныг надад Таны төлөө өдөр бүр амьдрах хүч чадал өгөн гэдэгт чинь итгэж байна.

Таны нэрээр би залбирлаа. Амен.

